

Борнуур нутаг

Уудам талд ургац нь халиурсан
Уул ус нь цэнхэрлэн алсарсан
Уртын дууны шуранхай хадсан
Ухаан тэлж сэтгэл цэлмээсэн
Бодлын үзүүрт сүүн цацалтай
Борхон зүрхний дуун хадгаа
Буйдхан холоос амин холбоотой
Баян тансаг Борнуур нутаг аа
Үржилт сүрэг нь хотлоор өссөн
Өнөр түмэн нь хотоор дэвжсэн
Наран хойморлож жаргал дэлгэрсэн
Насан уртсаж жавхаа нэмсэн
Бодлыг үзүүрт сүүн цацлтай
Ботгон буйдаатай ижий нутаг минь
Буйдхан холоос амин холбоотой
Буцаад ирмээр аав уулс минь
Буурал дээдсийн сүлд нь ивээсэн
Босоо хийморьтой заяа нь тэгширсэн
Бахдам ажлын бүтээл нь ундарсан
Буцашгүй урагшлах зам нь гэрэлтсэн
Дх: 1

Борнуур миний л нутаг

Хүннү түүхийг хадгалсан
Ноён хайрхан уулстай даа
Хөндий талд минь соёолсон
Хүслийн ногоон далайтай
Ай Бороо голын унага нь ээ
Босоо төрхийн угшилтай
Борнуур миний л нутгаа хө
Өөдөө цагаан хийморьтой
Сүмэн цагаан суврагууд нь
Эгэл түмнээ даагаасай даа
Сүжигт хайрхан уулынхаа
Эрдэнэс баялагаа дээжилье
Ай Бороо голын унага нь ээ
Босоо төрхийн угшилтай
Борнуур миний л нутгаа хө
Өөдөө цагаан хийморьтой
Бодол зүүдэнд сүмбэрлэсэн
Уулсын бараанд хорогдмоор оо
Борхон биенд шингээстэй
Усны тунгалагт эргэмээр ээ
Дх: 1